

# Покер

Хялбарчилсан покерын тоглолт явагдаж байгаа. Уг покерт тусгай хэзрийг ашиглана. Хэзрүүд дээр 1-ээс  $n$  хүртлэх тоог бичсэн байна. Тоо бүрийн хувьд уг тоотой хэзэр хязгааргүй олон байна.

Хялбарчилсан покерт зөвхөн стрэйт гэсэн ганц хослолыг ашигладаг. Энэ нь  $i, i+1, \dots, i+m-1$  гэсэн дараалсан  $m$  тоо бүхий хэзрүүд юм. Тоглоомын дүрмээр тоглогч бүрийн гарт  $s$  тооны хэзэр байх ба ширээн дээр  $m$  тооны хэзрийг дэлгэн тавьсан байна. Тоглогч бүр өөрийн харж буй  $s+m$  тооны хэзрөөс стрэйт үүсгэх  $m$  тооны хэзрийг сонгохыг оролдоно.

Та тэмцээн дээр ажиглагчаар оролцож байгаа тул зөвхөн ширээн дээр байгаа хэзрүүдийг л харж байгаа. Танд тоглогчдод хэдэн ялгаатай стрэйт үүсч болох нь сонирхолтой байгаа. Хоёр стрэйтийн хувьд ялгаатай хэзрөөс эхэлж байвал буюу өөрөөр хэлбэл дээр бичсэн тодорхойлолтын  $i$  тоогоороо ялгаатай бол тэдгээрийг ялгаатай стрэйтүүд гэнэ.

## Оролт:

Эхний мөрөнд  $n, m, s$  тоонууд өгөгдөх ба тэдгээр нь харгалзан хэзэр дээр байх хамгийн их тоо, ширээн дээр байгаа хэзрийн тоо болон гарт байх хэзрийн тоо болно ( $1 \leq n \leq 10^9, 1 \leq s < m \leq 10^5$ ).

Хоёр дахь мөрөнд 1-ээс  $n$  хүртлэх завсраас утгаа авах  $m$  ширхэг тоо байх ба тэдгээр нь ширээн дээр байх хэзрүүдийн утгууд болно.

## Гаралт:

Тоглогчдод гарч болох боломжит стрэйтүүдийн тоог хэвлэнэ.

## Жишээ:

оролт	гаралт
12 5 3	7
11 4 7 5 6	
12 7 3	0
4 4 4 4 4 4	

## Тайлбар:

Эхний жишээний хувьд 1, 2, 3, 4, 5, 6, 7 – гоос эхэлсэн стрэйтүүд байна.